

## **ХҮН АМ, НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

### **Ердийн хөдөлгөөн**

Эхний 3 сард аймгийн хэмжээнд 112 хүүхэд эхээс мэндэлсний 62 нь хүү, 50 нь охин байлаа. Нийт 27 хүн нас барсан байна. Бүртгүүлсэн гэр бүл 12, цуцалсан гэр бүл 2, үрчлэгдсэн хүүхэд 2 бүртгэгдлээ.

Он гарсаар тус аймагт 145 иргэн шилжин ирж , 132 иргэн шилжин явсан байна. Нийт шилжин ирэгсдийн 44,8 хувь нь , шилжин явагсадын 50,8 хувь нь эрэгтэйчүүд байна.

Төрөлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10,4 хувиар буурсан, нас баралт 44,4 хувиар өссөн , бүртгүүлсэн гэр бүл 33,3 хувиар буурсан, цуцалсан гэр бүл 3 дахин буурсан үзүүлэлт гарлаа. Харин үрчлэгдсэн хүүхдийн тоо 2 байгаа нь өмнөх оны мөн үетэй адил түвшинд байна.

### **Шинэ ажлын байр**

Оны эхний 3-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 465 байгаагаас 252 эмэгтэй буюу нийт ажилгүй иргэдийн 54,2 хувийг эзэлж байна.

Ажил идэвхтэй хайгч иргэдийг насны ангилалаар нь авч үзвэл 15-24 насны 118 үүнээс 66 эмэгтэй , 25-34 насны 116 үүнээс 67 эмэгтэй , 35-44 насны 122 үүнээс 67 эмэгтэй , 45-54 насны 85 үүнээс 45 эмэгтэй , 55-с дээш насны 24 иргэн байгаагаас 7 эмэгтэй байна.

Аймгийн хэмжээнд нийт ажил хайгч иргэдийн 6,2 хувь буюу 29 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.

Ажил хайгч иргэдийг боловсролын түвшингээр нь танилцуулбал 38,5 хувь нь бүрэн дунд , 23 хувь нь дипломын болон баклаврын дээд ,19,1 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн дунд , 13,8 хувь нь суурь боловсролтой , 5,3 хувь нь бага боловсролтой болон боловсролгүй иргэд байна.

Эхний улирлын байдлаар ажлын байрны захиалга 63 гарсан бол нийт ажилд орсон 35 иргэн байна . Үүнээс хөдөлмөрийн зуучлалаар ажилд орсон 29 иргэн байна.

Мөн хугацаанд нийт 19 ажлын байр шинээр бий болсон байна.

## Халамж үйлчилгээ

Оны эхний 3-р сарын байдлаар давхардсан тоогоор 2921 хүнд 400,3 сая төгрөгийн тэтгэвэр , тэтгэмж хөнгөлөлт , халамж үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад иргэдийн тоо 3,2 хувиар , тэтгэмж болгон олгосон мөнгөн дүн 36,8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Үүнээс :

Халамжийн тэтгэвэрт	306	хүнд	96,8	сая төгрөг
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	231	хүнд	49,2	сая төгрөг
Нөхцөлт мөнгөн тусламж	179	хүнд	12,9	сая төгрөг
Алдарт Э/о эхчүүдийн тусламж	1106	хүнд	149,9	сая төгрөг
Ахмад настны хөнгөлөлт	493	хүнд	12,3	сая төгрөг
Хөгжлийн/ бэр иргэдийн хөнгөлөлт	51	хүнд	14,9	сая төгрөг
Жирэмсэн амаржсан	547	хүнд	60,2	сая төгрөг
Ахмад дайчдын тэтгэмж	8	хүнд	4,1	сая төгрөг

Нийт 2921 хүнд 400,3 сая төгрөгийг халамжийн сангаас зарцуулсан байна.

## ХӨДӨӨ АЖ АХУЙ

### Мал төллөлт, төл бойжилт

1-р улирлын байдлаар төллөвөл зохих эх малын 27,9 хувь буюу 34900 мал төллөж, гарсан төл 34970 толгой, үүнээс 34854 төл бойжиж байна.

Мал төллөлт :

Сумд	Төллөвөл зохих хээлтэгч	Төллөсөн хээлтэгч	Төллөлтийн хувь	Хорогдсон төл	Бойжсон төл
Баянтал	18701	4656	24,9	0	4656
Сүмбэр	92443	22836	24,7	116	22720
Шивээговь	13758	7408	53,8	0	7478
ДҮН	124902	34900	27,9	116	34854

Төл бойжилт 99,7 хувьтай байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 5,5 хувиар өссөн үзүүлэлт гарлаа. Шивээговь Баянтал сумдад төлийн хорогдол гараагүй байна.

Мал төллөлтийн байдлыг аймгийн дүнгээр, таван төрөл дээр танилцуулбал:

Малын төрөл	Бүгд	Ингэ	Гүү	Үнээ	Эм хонь	Эм ямаа
Төллөсөн хээлтэгч	34900	19	108	444	18372	15957
Гарсан төл	34970	19	108	444	18392	16007
Хорогдсон төл	116	0	0	8	59	49
Бойжсон төл	34854	19	108	436	18333	15958

## Малын хорогдол

Он гарсаар аймгийн хэмжээнд том малын зүй бус хорогдол 94 гарсан нь өмнөх оны мөн үеэс 3,1 дахин буурсан байна.

### Малын хорогдлыг өнгөрсөн ономөн үетэй харьцуулбал:

Малын төрөл	2013 он	2014 он	Зөрүү
Бүгд	289	94	-195
Тэмээ	0	8	8
Адуу	7	1	-6
Үхэр	2	2	0
Хонь	97	45	-52
Ямаа	183	38	-145

3 дугаар сарын сүүлчийн байдлаар ХАА-н зарим нэр төрлийн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийг Сүмбэр сумын мэдээгээр харуулбал:

1. Хонины ноостой нэхий	5000 төгрөг
6. Богийн сүү, л	1100 төгрөг
7. Өндөг, ш	450 төгрөг
8. Ноолуур, кг	80000-86000 төгрөг
5. Боодолтой өвс	3500-4000 төгрөг

## АЖ ҮЙЛДВЭР

2014 оны 1-р улирлын байдлаар аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 10946,4 сая.төгрөгт, бүтээгдэхүүний нийт борлуулалт 10657.7 сая төгрөгт хүрээд байна.

Шивээ-Овоо Хувьцаат Компани нь нийт бүтээгдэхүүний 89,7 хувийг, нийт борлуулалтын 89,4 хувийг хийсэн байна.

Шивээ-Овоо хувьцаат компани нь зах зээл дээр 1 тонн нүүрсийг 19866 төгрөгөөр худалдаалж байна.

Шивээ-Овоо хувьцаат компаний борлуулалтын үзүүлэлтийг танилцуулбал:

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Жилийн эхнээс гүйцэтгэл
Бүтээгдэхүүн борлуулалт /үнийн дүнгээр/	Мян.төг	9533292,5
Нүүрс борлуулалт /биет хэмжээ/	Мян.тн	527,9
Нүүрс гаргалт /биет хэмжээ/	Мян.тн	9822059,4
Нийт бүтээгдэхүүн /үнийн дүнгээр/	Мян.төг	496,5
Ажиллагсдын тоо	Хүн	515

Өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт /аймгийн дүнгээр/ 11,9 хувиар,

Бүтээгдэхүүн борлуулалт /аймгийн дүнгээр/ 16.2 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байлаа.

## ТӨСӨВ, ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ, ДААТГАЛ

### Төсөв

Оны эхний 3-р сарын байдлаар орон нутгийн төсвийн орлого 856,5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 54,8 хувиар буюу 2,2 дахин буурсан байна.

Орон нутгийн орлогын гүйцэтгэлийг танилцуулбал:

/өссөн дүнгээр сая.төг/

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1.Орон нутгийн орлого	1060,2	856,5
2.Татварын орлого	935,2	692,3
3.Татварын бус орлого	33,2	72,2
5.Тусламжийн орлого	91,8	91,8

Үүнээс: Татварын орлогыг нарийвчлан үзүүлбэл:

(өссөн дүнгээр. сая.төг)

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Татварын орлого	935,2	692,3
- Орлогын албан татвар	751,2	559,8
- Өмчийн татвар	90,04	52,7
- Дотоодын бараа үйлчилгээний татвар	3,0	1,9
- Бусад татвар	90,9	77,8

Дээрх үзүүлэлтээс дүгнэхэд орон нутгийн орлогын биелэлт 80,8 хувийн , татварын орлогын биелэлт 74,03 хувийн биелэлттэй байна.

3-р сарын байдлаар аймгийн хэмжээгээр 3048,8 сая төгрөгийн зарлага санхүүжилт хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 27,1 хувиар өссөн байна.

Төсвийн зарлагын гүйцэтгэлийг танилцуулбал:

/өссөндүнгээрсая.төг/

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Бүх зарлага	3899,6	3048,8
Урсгал зардал	2821,8	2604,5
Хөрөнгийн зардал	1077,8	444,3
Төсөвт байгууллагын тоо	47	47
Төсөвт байгууллагын ажиллагсадын тоо	751	751

Дээрх үзүүлэлтээс дүгнэхэд төсвийн зардал 1-р улирлын байдлаар 21,8 хувийн хэмнэлттэй байна.

3-р сарын байдлаар төсөвт байгууллагын:

Өглөгийн үлдэгдэл 134,3 сая төгрөг

Авлагын үлдэгдэл 32,3 сая төгрөг болоод байна.

Өглөг авлагын мэдээнээс үзэхэд өглөг нь авлагаасаа 4,2 дахин их болсон байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулбал авлага 81,7 хувиар буюу 5,5 дахин , өглөг 54,7 хувиар 2,2 дахин өссөн үзүүлэлттэй байна.

## Нийгмийн даатгал

Тэтгэвэр

Мян.төг

Д/д	Төрөл	2013.03.25		2014.03.25	
		Хүний тоо	Тэтгэврийн дүн	Хүний тоо	Тэтгэврийн дүн
1	ӨН	1199	876726,5	1250	1014338,1
2	ТД	261	121638,3	269	147137,7
3	ТА	127	62794,9	127	71037,8
4	ҮО	68	67222,7	65	65976,1
	НИЙТ	1655	1128382,4	1711	1298849,7

Тэтгэмж

Мян.төг

Д/д	Төрөл	2013.03.25		2014.03.25	
		Хүний тоо	Тэтгэмжийн дүн	Хүний тоо	Тэтгэмжийн дүн
1	ХЧТА	202	19353,8	303	21619,0
2	ЖА	91	85730,1	75	80117,3
3	Оршуулга	9	2700,0	16	9920,0
4	ҮОМШӨ- ХЧТА	4	1386,5	12	4020,6
5	Ажилгүйдэл	24	26045,7	32	25059,1
	НИЙТ	330	1352216,1	438	140736,0

## Сайн дурын даатгал

Д/д	Сайн дурын даатгалын хамрагдалт	2013.03.25	2014. 03.25
1	Шинээр	31	71
2	Мөнгө тушаасан	424	486
3	Тушаасан мөнгөн дүн / мян.төг/	13275,9	19320,9

## Таван сангийн орлого , зарлагын харьцуулсан үзүүлэлт

Мян.төг

Д/д	Сангийн төрөл	Орлого			Зарлага		
		2013 оны 03 сар	2014 оны 03 сар	Өсөлт бууралт	2013 оны 03 сар	2014 оны 03 сар	Өсөлт бууралт
1	Тэтгэвэр	879749,8	573898,3	-305851,5	1061159,6	1232513,6	171353,9
2	Тэтгэмж	99365,3	65147,1	-34218,1	111825,7	89254,4	-22571,3
3	ЭМД	285953,3	170588,7	-115364,5	128877,7	180574,3	51969,6
4	ҮОМШӨ	115648,7	87624,3	-28024,3	68729,2	65976,2	-2753,0
5	Ажилгүйдэл	24425,0	16446,6	-7978,3	30554,0	24741,7	-5812,3
6	ДҮН	1405142,3	913705,3	-491437,0	14011146	1593060,2	191913,7

Оны эхний 3 сарын байдлаар 98 хүн тэтгэвэр тогтоолгосон байна.

## Даатгалын салбарууд

Говьсүмбэр аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Монгол даатгал , Мөнх даатгал , Ард даатгалын компаниудаас эхний улирлын байдлаар мэдээг авч танилцуубал :

/Мян,төг өссөн дүнгээр /

дд	Даатгалын бүтээгдэхүүний төрөл	2013 оны 1-р улирал	
		Орлого	Олгосон нөхөн төлбөр
1	Тээврийн хэрэгслийн даатгал	7116.1	4429.8
2	Жолоочийн хариуцлагын даатгал	2783.5	4564.4
3	Эд хөрөнгийн даатгал	819.7	0
4	Хөдөлмөрийн чадвар түр алдалтын даатгал	4249.8	200.0
5	Гэнэтийн ослын даатгал	2375.5	819.5
6	Мэргэжлийн хариуцлагын даатгал	976.0	0
7	Ачаа тээвэрлэлтийн даатгал	4484.8	0
8	Гэр хашаа байшингийн даатгал	35.0	0
9	Нийтийн ба хувийн сууцны даатгал	2083.6	0
10	Лангуу түрээслэгч жижиглэн худалдаа эрхлэгчдийн	368.7	0



даатгал			
11	Электрон тоног төхөөрөмжийн даатгал	16.5	0
12	Бараа материалын үлдэгдлийн даатгал	0	0
13	Нийт	<b>25309.2</b>	<b>10013.7</b>

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад даатгалын нийт орлого 6,2 хувиар , олгосон нөхөн төлбөр 39,9 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

## Банк

Он гарсаар аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа банкны салбаруудын мэдээг нэгтгэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад хадгаламж эзэмшигчид 14,8 хувиар , хадгаламжийн хэмжээ 26,9 хувиар өссөн байна.

Мөн зээл авсан аж ахуй нэгжийн тоо 6-р буюу 31,6 хувиар , олгосон зээлийн хэмжээ нь 3 дахин өссөн байна . Иргэдэд олгосон зээлийн хэмжээ 34,9 хувиар , малчдын зээлийн хэмжээ 12,5 дахин өссөн байна .

/өссөн дүнгээр/

Д/д	Үзүүлэлт	хэмжих нэгж	БАНК			
			2013 оны 3-р сар	2014 оны 3-р сар	Өсөлт бууралт	Өсөлтийн хувь
1	Хадгаламж эзэмшигчдийн тоо	хүн	9345	10966	1621	14,8
2	Хадгаламжийн хэмжээ	сая.төг	5623,6	7699	2075,4	26,9
3	Зээл авсан: ААНБ	тоо	13	19	6	31,6
4	Иргэд	хүн	6150	6210	60	1,0
5	Үүнээс : Малчид	хүн	132	222	90	40,5
6	Олгосон: зээл: ААНБ	сая.төг	257,6	921,9	664,3	3 дахин
7	Иргэд	сая.төг	22144,9	34045,9	11901,0	34,9
8	Үүнээс : Малчид	хүн	56,5	707,5	651,0	12,5 дахин
9	Зээлийн эргэн төлөлт	хувь	83,6	99,06	15,5	15,5
10	Харилцахын тоо	тоо	30656	31322	666	2,1
11	Харилцахын дүн	сая.төг	3107,6	3874,2	766,6	19,7
12	Карт эзэмшигчдийн тоо	хүн	15727	22189	6462	29,1

## ИХ БАРИЛГА

Их барилгын үйл ажиллагаа эрхэлдэг ААН байгууллагын үнийн мэдээнээс:

№	Материалын нэр ,төрөл	Хэмжих нэгж	2013 оны 1-р улиралд	2014 оны 1-р улиралд
1	Ханын гипс	м,кв	7,000	
2	Хар тосон түрхлэг	кг	170000	140000
3	Ердийн тоосго	ш	150-250	250-350
4	Шилэн хана/ хөнгөн цагаан рамтай /	м.кв	25,000-50,000	25,000-50,000
5	Ламинатан шал	м.кв	16,000	
6	Паркетан шал	м.кв	14,000	23000
7	Өнгөлгөөний хавтан /хиймэл хавтанцар/	м.кв	22,000	
8	Өнгөлгөөний хавтан /хиймэл чулуун /	м.кв	35,000	
9	Өнгөлгөөний хавтан /чулуун /	м.кв	12,000	
10	Хаалганы эвлүүлэг /модон/	м.кв	120,000	120000
11	Вакум цонх	м.кв	85,000	90000
12	Бүргэд хаалга	ш	250000	320000
13	Дүнзэнцэр 4-р зэрэг	м.куб	350,000	
14	Угаадаг ханын цаас	м.кв	6,000-7,000	7000-13000
15	Банз /32мм /	м.куб	350,000	330000
16	Цемент /М-400/ Хятад	тн	140,000-200,000	185000
17	Гантиг хавтан	м.кв	45,000	
18	Угаалтуур /600x450x150/	ком	50,000	80000
19	Суултуур	ком	80,000-150,000	150000
20	Дөрөвлөгч	ш	600-2800	
21	Ган яндан /ф-20 мм/	м	2800-4500	
22	Ган яндэн /ф-50мм/	м	5500-8500	
23	Хаалт /ф-400см/	ш	400,000-2000000	
24	Тоолуур/ САТ-ИТ/	ш	50000-350000	
25	Замын бетон хашлага	м	15000	
26	Явган хүний замын хавтан	м.кв	13000	15000
27	Хашаа	м	25000-45000	
28	Цахилгааны утас	м	600-2500	1300

Дээрх үзүүлэлтээс харахад 1-р улирлын байдлаар барилгын материалын дундаж үнэ бага зэрэг буурсан байна.

## ШУУДАН ХОЛБОО, ИНТЭРНЭТ

Шуудан холбоо интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын мэдээллийг оны эхний улирлын байдлаар авч үзвэл :

Үйлчилгээний нийт орлого 53670,4 төг байна . Үүнээс 32201,4 төгрөг нь хүн амаас орсон орлого байна.

Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2014 оны 1-р улирал
1	Үйлчилгээний нийт орлого	Мян . төг	53670,4
2	Хүн амаас орсон орлого	Мян . төг	32201,4
3	Суурин телефон цэг	Тоо	403
4	Айл өрхөд тавьсан суурин телефоны тоо	Тоо	192

Аймгийн хэмжээнд КАТВ-н сувагт холбогдсон хэрэглэгчдийн тоо 1326 байна.

Аймгийн холбооны газрын интернэт цэгийн үйлчилгээ

Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2014 оны 1-р улирал
1	Интернэтийн үйлчилгээний цэгийн тоо	Тоо	2
2	Интернэтийн үйлчилгээний цэгийн суудлын тоо	ширхэг	18
3	Интернэтийн үйлчилгээний цэгээр үйлчлүүлэгчдийн тоо	Тоо	750
4	Интернэтийн байнгын хэрэглэгчдийн тоо	Тоо	100

## ЭРҮҮЛ МЭНД , ЭМ ТАРИА

Аймгийн хэмжээний эрүүл мэндийн үзүүлэлтийг ЭМГ-ын 2014 оны 1 дүгээр улирлын мэдээгээр авч үзвэл:

Төрөлт- 122

Үүнээс: Амьд төрсөн хүүхэд - 123

Амьгүй - 1

Д/д	Үзүүлэлт	Үзлэгийн тоо	Эзлэх хувь
1	Нийт үзлэг	30342	100,0
2	Үүнээс: Урьдчилан сэргийлэх үзлэг	8944	29,5
3	Өвчний учир амбулаторын үзлэг	17663	58,2
4	Идэвхитэй хяналтын үзлэг	2335	7,7
5	Гэрийн үзлэг	1288	4,3
6	Гэрийн дуудлага	112	0,3

Түргэн тусламжийн дуудлага 2361 гарсны 153 нь буюу 6,5 хувь нь алсын дуудлага байлаа.

Аймгийн хэмжээгээр халдварт бус өвчлөл 1168, осол гэмтлийн өвчлөл 163, халдварт өвчин 27 гарсан байна.

Халдварт өвчнийг төрлөөр танилцуулбал :

Д/д	Халдварт өвчин	Өмнөх оны мөн үе	Оны эхнээс өссөндүнгээр
1	Цусан суулга	-	-
2	Сальмонеллэз	-	-
3	Гепатит	6	2
4	Сүрьеэ	2	1
5	Менингококт халдвар	-	-
6	Гар хөл амны өвчин	1	-
7	Салхин цэцэг	15	10
8	Гахайн хавдар	1	1
9	Хамуу	-	-
10	Мөөгөнцөр	-	-
11	Заг хүйтэн	6	1
12	Тэмбүү	24	8
13	Трихоманиаз	8	2
14	Ёлом	-	1
15	Бусад / ангилагдаагүй /	-	1

Өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

Халдварт бус өвчлөл 46,8 хувиар

Осол гэмтлийн өвчлөл 32,6 хувиар,

Халдварт өвчний өвчлөл 79,7 хувиар тус тус буурсан байна.

Халдварт өвчний 37,04 хувийг салхин цэцэг , 40,7 хувийг БЗХӨ 22,3 хувийг бусад өвчлөл эзэлж байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эмийн сангуудын мэдээнээс танилцуулбал:

Оны эхний 3-р сарын байдлаар аймгийн хэмжээнд 5 эмийн сан үйл ажиллагаагаа эрхэлж байна . Эдгээр эмийн сангуудаас мэдээг авч нэгтгэснээр аймгийн хэмжээнд 121202.7 төгрөгийн эм тариа татан авч, 121631.5 төгрөгийн эм тарианы борлуулалт хийсэн байна.

Одоогийн байдлаар 134835.1 төгрөгийн эм тариа бусад зүйлсийн нөөцтэй байна.

## **ГЭМТ ХЭРЭГ**

Аймгийн хэмжээнд он гарсаар 57 гэмт хэрэг бүртгэгдсэн ба тус гэмт хэргийн 26 нь буюу 45,6 хувь нь хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг байлаа. Гарсан гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 1,9 дахин буюу 50,9 хувиар өссөн байна.

Гэмт хэрэгт холбогдогсод 55, үүний 34 нь буюу 61,8 хувь нь ажилгүй иргэдийн үйлдсэн гэмт хэрэг байна. Гэмт хэрэгт холбогдогсодыг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 2,3 дахин өссөн байна. .

Давхардсан тоогоор 439 хүн эрүүлжүүлэгдэж ,51 хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад эрүүлжүүлэгдсэн хүний тоо 2,2 дахин , баривчлагдсан хүний тоо 3 дахин өссөн үзүүлэлт гарлаа.

Гэмт хэрэг зөрчлийг төрлөөр нь танилцуулбал:

№	Гэмт хэргийн төрөл	Хэргийн тоо		Өсөлт бууралт	
		2013 он	2014 он	тоо	хувь
1	Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг	18	26	2	11,8
2	Өмчлөх эрхийн эсрэг	3	17	11	5,7 дахин
3	Нийгмийн аюулгүй байдлын эсрэг	4	3	-1	-33,3
4	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	3	7	4	2,3 дахин
5	Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг	1	0	-1	-100
6	Хүүхэд гэр бүлийн нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	0	1	0	1 дахин
7	Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	0	1	0	0
8	Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг	0		0	0
9	Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг	0	1	0	1 дахин
10	Иргэдийн улс төрийн болон бусад эрх эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	0	1		
11	Бүгд	29	57	0	43,6

Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь эхний 3 сарын байдлаар 62,1 хувьтай байна.

Гэмт хэргийн улмаас нас барсан 6 , гэмтсэн 38 тохиолдол гарч нийт хохирлын хэмжээ 62,1 сая төгрөгт хүрсэн байна.

Эхний улирлын байдлаар аймгийн хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэргийг ангиллаар нь авч үзвэл :

- Онц хүнд гэмт хэрэг 2
- Хүнд гэмт хэрэг 2
- Хүндэвтэр гэмт хэрэг 18
- Хөнгөн гэмт хэрэг 35 гарсан байна.

## ЦАГ УУР

2014 оны 3 дугаар сард агаарын дундаж температур -2.5 хэм байгаа нь өмнөх оны мөн үеэс 2,1 хэмээр дулаан , хамгийн их температур 5,2 хэм, хамгийн бага температур -9,5 хэм байлаа . Хөрсний температурыг авч үзвэл дундаж нь 0,4 хэм байгаа нь өмнөх оны мөн үеэс 2,3 хэмээр дулаан , хамгийн их нь 23,5 , хамгийн бага нь -12,7 хэм байлаа. Тундасны хэмжээ 0,0 байгаа нь өмнөх оны мөн үеэс 2,3 мм-ээр бага, тундастай өдрийн тоо 3 байгаа нь өмнөх оны мөн үетэй адил байна , салхины хурд хамгийн ихдээ 18 м/с байсан нь өмнөх оны мөн үеэс 2 м/с-ээр бага , 10 м/с –ээс дээш салхитай өдөр 3 байгаа нь өмнөх оны мөн үеэс 2,3 дахин их байлаа. Дээрх үзүүлэлтүүдээс дүгнэхэд тайлант оны 3 дугаар сар нь өмнөх оны мөн үеэс илүү дулаан, тунадас багатай хуурайдуу болон салхи ихтэй сар байв.

**Статистикийн хэлтэс**

2014-03-14

---

Хаяг: [govisumber@nso.mn](mailto:govisumber@nso.mn)

Утас: 70543222, 70543017

Вэб: [govisumber@nso.mn](mailto:govisumber@nso.mn)